

“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” САТРЕПС ТӨСЛИЙН ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГУРАВДУГААР ХУРАЛ

НЭМГ-ЫН ДАРГА, ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Д.БАЯРБОЛДЫН ХЭЛЭХ ҮГ

Огноо: 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 09 цагт

Хаана: ЭМЯ-ны 1 давхарт хурлын Б заал

Зориулалт: “Сүрьеэ болон ям өвчний хяналт” САТРЕПС төслийн ХЗХ-ны гуравдугаара хурал

Хугацаа: 10 минут орчим

Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Сүрьеэ болон ям өвчний хяналт төсөл” нь Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, Японы Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2020 оны 11 дүгээр сараас Монгол Улсад хэрэгжиж одоогийн байдлаар 4 дэх жилдээ амжилттай үргэлжилж байна.

Төслийг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон Улсын Хоккайдогийн их сургууль, Япон Улсын сүрьеэ судлалын хүрээлэн хамтран хэрэгжүүлж байна. Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Сангийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв уг төслийг дэмжин, хамтран ажиллаж ирсэн билээ.

Энэ хугацаанд төслийн хамтарсан зохицуулах хорооны хурлыг бид 3 дахь удаагаа хамтран зохион байгуулж төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй бэрхшээл, хурлын оролцогчидтой санал солилцож асуудлыг шийдвэрлэн өнөөдрийг хүртэл үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс төдийгүй дэлхий дахинд аюул учруулсан Ковид-19-ын нөхцөл байдлыг амжилттай даван туулж, хамтарсан зохицуулах хорооны өмнөх хоёрдугаар хурлаас хойш 2023 онд бид төслийн хэрэгжилтэд асар олон ахиц дэвшлийг гаргаж ложистикийн асуудлыг амжилттай шийдвэрлэж, 2023 оны эхний хагас жилд төслийн тоног төхөөрөмжийг Монгол руу татан авч оношилгоонд ашиглаж чадлаа.

Боловсон хүчний чадавхийг сайжруулах зорилгоор хилийн чанад дах сургалтанд хоёр байгууллагын 15-16 мэргэжилтэнг сургаж дэвшилтэт технологийг ашиглах суурь чадварыг эзэмшүүлэд байна.

Төслийн зөвлөхүүд Монгол Улсад ирж тоног төхөөрөмж суурилуулах, ажлын байранд мэргэжилтэнг сургахын зэрэгцээ Япон Улсын профессор, эмч мэргэжилтнүүд Монгол судлаачидтай хамтран судалгааг гүйцэтгэж, хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Төслийг амжилттай хэрэгжихэд Япон-Монгол хоёр улсын төрийн байгууллагууд, Жайка, АМЕД байгууллагын хамтын ажиллагаа, Төслийн зөвлөх профессор Такаши Кимүра, профессор Сатоши Митарай, профессор Ясухико Сүзүки, профессор Охаши Казүхико нарын хүчин чармайлт

их нөлөөтэй байсныг дурдаж төслийн захирлын нэрийн өмнөөс гүнээ талархал илэрхийлж байна.

2024, 2025 он бол энэхүү төслийн хэрэгжилтийн шийдвэрлэх жил бөгөөд төслийн хүрэх 4 үр дүн болох үхрийн сүрьеэ болон ям өвчний халдварыг илрүүлэхэд дэвшилтэт технологийг хэрэглээнд нэвтрүүлж Монгол Улсад одоогийн хэрэглэгдэж байгаа сүрьеэ, ям өвчнийг оношлох аргыг шинэчлэх, адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зооноз өвчний тархалт, халдварлалтын бодит нөхцөл байдлыг ийлдэс судлал, молекул биологийн аргаар тогтоох, нэг эрүүл мэнд (One health) үзэл баримтлалд тулгуурласан зоонозын халдварт өвчнийг хянах платформыг бий болгох томоохон зорилт бидний өмнө тавигдаж байна.

Өнөөдрийн хамтарсан зохицуулах хорооны гуравдугаар хурлаар бүх хамтрагч талуудын төслийн хэрэгжилтийн явцын талаарх илтгэлийг сонсож, цаашид анхаарах асуудлыг хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргана хэмээн найдаж байна.

Ингээд өнөөдрийн хуралд оролцож буй төслийн удирдлага, багийн гишүүд болон ажиглагч гишүүддээ талархал илэрхийлж, хурлыг нээж байна.

Өнөөдрийн хуралд амжилт хүсье. Баярлалаа

“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” ТӨСЛИЙН ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

НЭМГ-ЫН ДАРГА, ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Д.БАЯРБОЛДЫН ХЭЛЭХ ҮГ

Огноо: 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 13 цагт

Хаана: ЭМЯ-ны 1 давхарт хурлын Б заал

Зориулалт: “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын нээлт

Хугацаа: 10 минут орчим

Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Сүрьеэ болон ям өвчний хяналт төсөл” нь Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, Японы Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2020 оны 11 дүгээр сараас Монгол Улсад амжилттай хэрэгжиж байгааг үдээс өмнөх хуралдаа тэмдэглэн хэлж байсан.

Үдээс өмнөх Хамтарсан зохицуулах хорооны гуравдугаар хурлаар төслийн хүрэх үр дүнг цаашид төслийн хэрэгжилтийг хэрхэн эрчимжүүлэх талаар бид ярилцаж тодорхой шийдвэрүүдэд хүрлээ.

Сүрьеэ болон ям өвчний эрдэм шинжилгээний энэхүү хамтарсан төслийн үр дүн нотолгоонд суурилсан шинжлэх ухаанч, үр дүнгээр тодорхойлогдох учиртай. Иймд Төслийн хэрэгжилтийн үр дүн бидний өнөөдрийн болон цаашид хэрэгжих судалгааны ажлын үр дүн, олон нийтэд хэрхэн түгээн дэлгэрүүлсэнээр хэмжигдэх юм. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд жил тутам олон улсын хурал зохион байгуулагдахаар тусгагдсан хэдий ч төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан өнөөдөр бид анхны эрдэм шинжилгээний олон улсын хурлаа хийж байна.

Эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр ёсоор хурал маань 3 хэсэгт хуваагдах ба хэсэг тус бүр 4-5 илтгэл тавигдахаар төлөвлөгдсөн байгаа. Энэхүү илтгэлүүд нь тухайн төслийн хүрээнд явагдсан судалгааны үр дүнгээс манай судлаачид танилцуулах юм. Мал эмнэлэг болон хүн эмнэлгийн хүрээнд хийгдэж байгаа энэхүү судалгааг Япон улсын профессор, эмч мэргэжилтнүүд Монгол судлаачидтай судалгааг хамтран гүйцэтгэж, хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Бид өнөөдрийн хурлаар бүх хамтрагч талуудын эрдэм шинжилгээ судалгааны илтгэлүүдийг сонсож цаашид анхаарах асуудлыг хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргана хэмээн найдаж байна.

Ингээд хуралд оролцож буй төслийн удирдлага, багийн гишүүд, эрдэмтэн судлаач нартаа талархал илэрхийлж хурлыг нээснийг мэдэгдэж байна.

Илтгэгч нартаа амжилт хүсье баярлалаа.